

Удирдах зөвлөлийн 2024 оны 05 дүгээр сарын 02-ны өдрийн

02 дугаар тогтоолын хавсралт



ТАЛУУДЫН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

- 1.1. ҮҮПК-ийн аюулгүйн бүсийн дотор тус сургуулийн үйл ажиллагаатай хамаарал бүхий талуудын хувийн өмч, бараа материал, тоног төхөөрөмж, машин техник, багаж хэрэгсэл, эд зүйлс алдагдах, эвдрэх түүнийг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Сургуулийн дүрэм, дотоод журам, тэдгээртэй нийцсэн хууль тогтоомжуудтай харилцан уялдсан
- 1.3. **Хоёр: Журмын нэр томъёо:**
 - 2.1. Аюулгүйн бүс: Тус сургуулийн эзэмшил газар, хайс, хамгаалалтын доторх хязгаарлагдсан бүс
 - 2.2. Хувийн өмч: хувь хүн, аж ахуйн нэгж, хоршоо, хувьцаат, оюуны, зохиогчийн эрх болон төрийн бус өмчийн бусад хэлбэрүүд орно. Өөрөөр хэлбэл хувьдаа өмчилж буй хуулиар хориглосноос бусад үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, оюуны үнэт зүйл, эрх

2.3: Талууд: Суралцагч, эцэг эх, харгалзан дэмжигч, үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогчид

Гурав: Талуудын өмчийн хамгаалалт

- 3.1. Суралцагчдын хувийн хэрэг, гэрчилгээг сургалтын алба, төгсөлтийн дараах боловсролын баримт бичгийг архив хариуцаж хадгална.
- 3.2. Суралцагчдын цахим мэдээлэл, статистик, банкны дансны мэдээллийн аюулгүй байдлыг сургууль /холбогдох багш, ажилтан/, суралцагч хангаж ажиллана.
- 3.3. Талууд албан ёсоор сургуульд хүлээлгэж өгөөгүй хувийн өмч, эд хөрөнгийн аюулгүй, бүрэн бүтэн байдлыг өөрөө хариуцна.
- 3.4. Багш, ажилтан, харгалзан дэмжигч нар талуудад өмч хөрөнгийн аюулгүй байдал, хадгалалт, хамгаалалтын талаар анхааруулга сэрэмжлүүлэг өгнө.
- 3.5. Ёс зүйн хэм хэмжээг сахих, бусдын эд хөрөнгөд хүндэтгэлтэй хандах сурталчилгаа мэдээллийг зохион байгуулна.
- 3.6. Талууд ҮУПК-ын дүрэм, журмыг хүндэтгэн дагаж мөрдөнө.
- 3.7. Дотуур байранд суугчид нь суралцагчийн дотуур байрын журмыг мөрдөнө.
- 3.8. Бусдын өмчийг дур мэдэн хууль бусаар авах, ашиглах, захиран зарцуулахыг хориглоно.
- 3.9. Шаадлагатай гэж үзвэл талууд харуул хамгаалалтын ажилтан, эсвэл тухайн ажил үйлчилгээгээр харилцан хамааралтай багш, ажилтанд хувийн өмчөө албан ёсоор хүлээлцэж болно. Энэ тохиолдолд тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурна.
- 3.10. Хэрэв талуудын хувийн өмч алдагдвал камер шүүлгэж болно.
- 3.11. Анги, дадлагын газар дахь суралцагч, хувь хүний цүнх, хичээлийн хэрэгсэл, хувцас, гар утас зэргийг өөрөө хариуцаж хамгаална.
- 3.12. Гадны зочдын хувцас, хэрэглэлийг тусгай өлгүүр, өрөөнд байрлуулах ба хадгалалт, хамгаалалтыг сургуулийн томилсон ажилтан хариуцна.
- 3.13. Камерыг Захиргаа, аж ахуйн менежер, эсвэл Нийгмийн ажилтаны зөвшөөрлөөр сүлжээний мэргэжлийн багш, ажилтнаар шүүлгэж, холбогдох эзнийг тодруулан тэмдэглэл хөтлөж, шаардлагатай гэж үзвэл Хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлнэ.